

## **18. ТӨСӨЛ ХЭРХЭН БИЧИХ ВЭ?**



|                                                   |     |
|---------------------------------------------------|-----|
| 18-1. Төсөл бичихэд урьдчилан анхаарах зүйл ..... | 255 |
| 18-2. Төслийн баримт бичгийн бүрэлдэхүүн .....    | 255 |
| 18-3. Төслийн үр дүнг тодорхойлох (Жишээ) .....   | 261 |

Бизнес төсөл бичих гэдэг бол тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч, хамтрагч талд шаардлагатай мэдээллийг (төлөвлөгөө) бэлтгэн танилцуулж байгаа хэлбэр юм. Төсөл нь тооцоо судалгаанд үндэслэсэн тодорхой цаг хугацаанд, тодорхой нөөцийг ашиглан төлөвлөсөн үр дүнд хүрэх цогц үйл ажиллагаа юм.

### **18-1. Төсөл бичихэд урьдчилан анхаарах зүйл**

- ✓ Ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч, хамтрагч талын үйл ажиллагааны чиглэл таны бичих төслийг дэмжихэд тохирч байгаа эсэхийг нягтлах
- ✓ Төсөл болгон хэрэгжүүлэх гэж буй үйл ажиллагаанд оролцох, хамрагдах хүмүүсийн санал бодлыг сонсох, нэгтгэх
- ✓ Төслийн хүрээнд худалдан авах эд зүйлсийн үнэ, тээврийн зардал, ажиллах хүчин, түүний зардал, цаг хугацааны нөөц боломж, газрын зөвшөөрөл байгаа эсэх, статистикийн тоон мэдээлэл харах, урьд өмнө хэрэгжсэн ижил төстэй төслийн мэдээлэл харах зэрэг бусад судалгааг хийх.

### **18-2. Төслийн баримт бичгийн бүрэлдэхүүн**

1. Төслийн хураангуй
2. Төслийн танилцуулга
3. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл
4. Зорилго, зорилт
5. Үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Төсвийн зарцуулалт
7. Төслийн үр дүнг тодорхойлох
8. Төслийн тайлан бичих
9. Хавсралт материал

- *Төслийн хураангуй*

Энд төслийн талаарх мэдээллийг нэг хуудсанд товч, тодорхой багтаах ба энэ нь богино хугацаанд санхүүжүүлэгч талыг ерөнхий мэдээллээр хангаж чадахуйц байх шаардлагатай.

## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

Жишээ: “Зөгийн бал савлах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах, зөгийн өвөлжих байр барих” төсөл

|                                                                    |                                                                                                                                                                                                                                                        |
|--------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Төслийн нэр                                                        | “Зөгийн бал савлах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах, зөгийн өвөлжих байр барих ” г.м.                                                                                                                                                           |
| Төсөл хэрэгжүүлэх талын холбоо барих хаяг                          | “Хатан эх” зөгийчдийн холбоо, ТББ<br>Дархан-Уул аймаг, Дархан сум .....-р баг, .... байр, .... тоот<br>Утас: .....<br>И-мэйл: .....<br>FB хуудас: “Хатан эх” зөгийчдийн холбоо гэх мэт                                                                 |
| Төсөл хэрэгжих газар                                               | Дархан-Уул аймгийн Орхон сумын ....-р багт                                                                                                                                                                                                             |
| Төсөл хэрэгжих хугацаа                                             | .....                                                                                                                                                                                                                                                  |
| Төслийн нийт төсвийн мөнгөн дүн (төгрөг)                           | .....                                                                                                                                                                                                                                                  |
| “Хатан эх” зөгийчдийн холбоо, ТББ-аас хариуцах зардал (төгрөг)     | .....                                                                                                                                                                                                                                                  |
| Спонсроос хүсэж буй санхүүжилтийн хэмжээ (төгрөг)                  | .....                                                                                                                                                                                                                                                  |
| Спонсроос олгосон санхүүжилтыг эргэн төлөх сүүлийн хугацаа         | 20.. оны ....-р сар<br>(Хэрэв эргэн төлөх шаардлагагүй бол энэ хэсгийг хасах)                                                                                                                                                                          |
| Төлөвлөсөн үйл ажиллагааны нийт үргэлжлэх хугацаа                  | Дөрвөн сар (20.. оны ..... аас .....-р сар)                                                                                                                                                                                                            |
| Хүлээгдэх үр дүн, шалгуур үзүүлэлт                                 | “Хатан эх” зөгийчдийн холбооны гишүүн ..... зөгийчин өрх хамтран ашиглах зөгийн бал савлах багаж болон ..... бүл зөгий өвөлжих байр бий болно.                                                                                                         |
| Төслийн хамрах хүрээ (Төслийн үр ашгийг хүртэгсэд)                 | “Хатан эх” зөгийчдийн холбооны гишүүн ..... зөгийчин өрхийн ..... зөгийчин                                                                                                                                                                             |
| “Хатан эх” зөгийчдийн холбоо, ТББ-аас төслийг хариуцан ажиллах баг | Төслийн менежер: Д.Долгормаа “Хатан эх” зөгийчдийн холбоо, ТББ-ын гүйцэтгэх захирал<br>Худалдан авалт, санхүү хариуцагч: .....<br>“Хатан эх” зөгийчдийн холбоо, ТББ-ын гишүүн<br>Барилгын ажил хариуцагч: .....<br>Хүний нөөц хариуцагч: ..... гэх мэт |
| Хамтран ажиллах, зөвлөх байгууллага, хүмүүс                        | -Дархан-Уул аймгийн Орхон сумын сумын ЗДТГ<br>-Монголын зөгийчдийн нийгэмлэг<br>-Орон нутаг дахь барилгын бригад эсвэл ..... барилгын компани<br>- Зөгийчдийн холбооны гишүүд г.м.                                                                     |

### - *Төслийн танилцуулга*

Төслийг санаачлагч, хэрэгжүүлэх байгууллага, үйл ажиллагааг хариуцагч нарын мэдээллийг агуулдаг. Үүнд:

- Байгууллагын товч танилцуулга
- Үйл ажиллагааг хариуцагч нарын туршлага, ур чадвар
- Зөвлөх байгууллага, хүмүүсийн товч мэдээлэл
- Төсөл үр дүнд хүрэх итгэл, үнэмшил

### - *Төсөл хэрэгжүүлэх үндэслэл*

Энэ хэсэгт тус төслийг зайлшгүй хэрэгжүүлэх болсон шалтгааныг бичнэ. Үүний тулд өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа болон энэ нь зөгийн аж ахуйд болон зөгийн балны үйлдвэрлэлд хэрхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг бичих шаардлагатай. Тэгээд төсөл хэрэгжсэний үр дүнд дээрх асуудлууд хэрхэн шийдвэрлэгдэх боломжтой тухай 10 орчим өгүүлбэрт багтаан товч илэрхийлэх.

### - *Төслийн зорилго, зорилт*

#### **Зорилго: (Project Purpose)**

Энд төсөл хэрэгжсэнээр зөгийн аж ахуй, зөгийчдийн холбооны үйл ажиллагаанд болон зөгийчдийн амьдралд ямар эерэг зүйл бий болох тухай бичнэ. Өөрөөр хэлбэл энэ хэсэгт юуг бий болгох тухай бичнэ.

Жишээлбэл: Зөгийн балны чанар, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зөгийн бал савлах иж бүрэн тоног төхөөрөмжтэй болох мөн зөгийн бүл эрсдэлгүй өвөлжих нөхцөл хангасан өвөлжөөний байртай болох гэх мэтийг дурьдаж бичнэ.

#### **Зорилт: (Overall Goal)**

Энэ хэсэгт дээр бий болгосон зүйлүүдийг юуны төлөө, яах гэж бий болгосон тухай бичнэ. Жишээлбэл: 1. Манай зөгийн аж ахуй эсвэл зөгийчдийн холбооны гишүүн зөгийчдийн хийж буй бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн тогтвортой байдлыг хангах 2. Жил бүр тэдэн бүл зөгийг эрсдэлгүй (хорогдолгүй) өвөлжих нөхцөлөөр хангах гэх мэтээр бичих.

### - *Үйл ажиллагааны төлөвлөгөө*

Үйл ажиллагааны төлөвлөгөөг доорх байдлаар хүснэгтэнд бичиж болох юм.

## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

### Зорилт-1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Жишээ: Зөгийн бал савлах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Үйл ажиллагаа                                      | Хэрэгжүүлэх арга                     | Хариуцах эзэн<br>Бусад хүний нөөц | Хугацаа           |
|---|----------------------------------------------------|--------------------------------------|-----------------------------------|-------------------|
| 1 | Зөгийн бал халаагуур (загвар) худалдан авах        | Хаанаас, яаж худалдан авч ирэх тухай | Хариуцах хүний нэр                | 2021.5.08 ~ 06.08 |
| 2 | Зөгийн бал савлах төхөөрөмж (загвар) худалдан авах | Хаанаас, яаж худалдан авч ирэх тухай | .....                             | .....             |
| 3 | Зөгийн бал савлах төхөөрөмж суурилуулах            | Хэн, яаж суурилуулах тухай           | .....                             | .....             |
| 4 | ..... г.м.                                         |                                      |                                   |                   |

Тайлбар: Үйл ажиллагааг дарааллын дагуу бичих

### Зорилт-2-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Жишээ: Зөгийн өвөлжих байр барих үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Үйл ажиллагаа        | Хэрэгжүүлэх арга                     | Хариуцах эзэн<br>Бусад хүний нөөц | Хугацаа           |
|---|----------------------|--------------------------------------|-----------------------------------|-------------------|
| 1 | Мод худалдаж авах    | Хаанаас, яаж худалдан авч ирэх тухай | Хариуцах хүний нэр                | 2021.7.08 ~ 07.15 |
| 2 | Цемент худалдаж авах | Хаанаас, яаж худалдан авч ирэх тухай | .....                             | .....             |
| 3 | Суурь цутгах         | Хэн, яаж хийх тухай                  | .....                             | .....             |
| 4 | ..... г.м.           |                                      |                                   |                   |

### Зорилт-1-ийн хүрээнд хийх худалдан авалтын төлөвлөгөө

Жишээ: Зөгийн бал савлах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах төсвийн зарцуулалтын төлөвлөгөө

| № | Материалын нэр /<br>Хэмжих нэгж      | Тоо,<br>ширхэг | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Бүгд үнэ<br>(төгрөг) |
|---|--------------------------------------|----------------|----------------------------|----------------------|
| 1 | Зөгийн бал халаагуур (ширхэг)        | ....           | ....                       | ....                 |
| 2 | Зөгийн бал савлах төхөөрөмж (ширхэг) | ....           | ....                       | ....                 |
| 3 | .....                                |                |                            |                      |
| 4 | Нийт                                 |                |                            | .....                |

## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

Зорилт-2-ын хүрээнд хийх худалдан авалтын төлөвлөгөө

Жишээ: Зөгийн өвөлжих байр барих үйл ажиллагааны төсвийн зарцуулалтын төлөвлөгөө

| № | Материалын нэр /<br>Хэмжих нэгж | Тоо,<br>ширхэг | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Бүгд үнэ<br>(төгрөг) |
|---|---------------------------------|----------------|----------------------------|----------------------|
| 1 | Дүнз мод худалдаж авах (м3)     | .....          | .....                      | .....                |
| 2 | Цемент худалдаж авах (тонн)     | .....          | .....                      | .....                |
| 3 | .....                           |                |                            |                      |
| 4 | Нийт                            |                |                            | .....                |

Худалдан авалтын төлөвлөгөөг үйл ажиллагааны төрөл тус бүр дээр хийгээд эцэст нь доорх байдлаар нэгтгэх шаардлагатай.

### Ажлын хөлсний тооцоо (Жишээ)

| №                                                   | Оролцох хүмүүс           | Ажиллах өдөр | Өдөрт ногдох<br>цалин (төгрөг) | Бүгд (төгрөг) |
|-----------------------------------------------------|--------------------------|--------------|--------------------------------|---------------|
| Зорилт -1-ийн үйл ажиллагаанд зарцуулах ажлын хөлс: |                          |              |                                |               |
| 1                                                   | Худалдан авалт хариуцагч | .....        | .....                          | .....         |
| 2                                                   | Туслах ажилтан           | .....        | .....                          | .....         |
| 3                                                   | .....                    | .....        | .....                          | .....         |
| Зорилт -2-ын үйл ажиллагаанд зарцуулах ажлын хөлс:  |                          |              |                                |               |
| 1                                                   | Материал худалдан авах   | .....        | .....                          | .....         |
| 2                                                   | Суурь цутгах             | .....        | .....                          | .....         |
|                                                     | .....                    | .....        | .....                          | .....         |
|                                                     | Нийт                     |              |                                | .....         |

### Тээврийн зардлын тооцоо (Жишээ)

Тээврийн хэрэгслийн түрээс:

| № | Ашиглах үйл ажиллагаа | Ашиглах өдрийн<br>тоо | Өдрийн түрээс<br>(төгрөг) | Бүгд (төгрөг) |
|---|-----------------------|-----------------------|---------------------------|---------------|
| 1 | Зорилт 1              | .....                 | .....                     | .....         |
| 2 | Зорилт 2              | .....                 | .....                     | .....         |
| 3 | .....                 | .....                 | .....                     | .....         |
| 4 | Нийт                  |                       |                           | .....         |

Хэрэв тээврийн хэрэгсэл түрээслэхгүй бол дээрх хүснэгтийг хийх шаардлагагүй юм.

## ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

### Шатахууны зардал: (Жишээ)

| № | Зориулалт | Маршрут | Явах зай | Зарцуулах шатахуун | Бүгд (Төгрөг) |
|---|-----------|---------|----------|--------------------|---------------|
| 1 | Зорилт 1  |         |          |                    |               |
| 2 | Зорилт 2  |         |          |                    |               |
| 3 | .....     |         |          |                    |               |
| 4 | Нийт      |         |          |                    |               |

### Нийт төсвийн тооцоо (Жишээ)

| № | Зориулалт                        | Төсөв (Төгрөг) | Санхүүжүүлэгч тал            |
|---|----------------------------------|----------------|------------------------------|
| 1 | Зорилт -1-ийн төсвийн зарцуулалт | .....          | -                            |
| 2 | Зорилт -2-ын төсвийн зарцуулалт  | .....          | -                            |
| 3 | Ажлын хөлс                       | .....          | “Хатан эх” зөгийчдийн холбоо |
| 4 | Тээврийн хэрэгслийн түрээс       | .....          | -                            |
| 5 | Шатахууны зардал                 | .....          | -                            |
| 6 | .....                            | .....          | -                            |
|   | Нийт төсөв                       | .....          | -                            |

### Спонсороос хүсэж буй санхүүжилтийн хэмжээ: (Жишээ)

| № | Зориулалт                        | Санхүүжилтийн хэмжээ (Төгрөг) |
|---|----------------------------------|-------------------------------|
| 1 | Зорилт -1-ийн төсвийн зарцуулалт | .....                         |
| 2 | Зорилт -2-ын төсвийн зарцуулалт  | .....                         |
| 3 | Тээврийн хэрэгслийн түрээс       | .....                         |
| 4 | Шатахууны зардал                 | .....                         |
| 5 | ....                             | .....                         |
|   | Нийт                             | .....                         |



### 18-3. Төслийн үр дүнг тодорхойлох

Төслийн үр дүнг тооцохдоо доорх байдлаар хүснэгтээр харуулж болно.  
(Жишээ)

| № | Хэрэгжүүлэх ажил                                          | Хүрэх үр дүн                                                                                                                           | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                    |
|---|-----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Зөгийн бал савлах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах | “Хатан эх” зөгийчдийн холбоо нь зөгийн балны чанар, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зөгийн бал савлах иж бүрэн тоног төхөөрөмжтэй болох | “Хатан эх” зөгийчдийн холбооны гишүүн зөгийчид хамтран ашиглах зөгийн бал савлахад шаардлагатай зөгийн бал халаагуур, савлагаа хийх тоног төхөөрөмж ... зэрэг зүйлүүд ашиглахад бэлэн болсон байна. |
| 2 | Зөгийн өвөлжих байр барих                                 | “Хатан эх” зөгийчдийн холбоо нь зөгийн бүл эрсдэлгүй өвөлжих нөхцөл хангасан өвөлжөөний байртай болох                                  | “Хатан эх” зөгийчдийн холбооны гишүүн зөгийчид хамтран ашиглах зөгийн бүл эрсдэлгүй өвөлжих нөхцөл хангасан өвөлжөөний байр бэлэн болсон байна.                                                     |
| 3 | ..... г.м.                                                | .....                                                                                                                                  | .....                                                                                                                                                                                               |

- *Төслийн тайлан бичих*

Төсөл хэрэгжсэн хугацаанд хийсэн ажлынхаа дүнг спонсорлогч талд танилцуулж үнэлэлт дүгнэлт авах үйл явц нь тайлан юм. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрхэн хийж гүйцэтгэсэн болон гарсан үр дүнг бичсэн зүйл нь тайлан болдог.

Тайлангийн бүтцэд дараах зүйлүүд орно. 1) Хэрэгжсэн төслийн товч танилцуулга 2) Үндсэн үйл ажиллагаануудын тус бүр хэрэгжсэн байдал 3) Зарцуулсан төсвийн тооцоо 4) Дүгнэлт

Төслийн үйл ажиллагааг фото зургаар баримтжуулж тайланд оруулах нь чухал байдаг.

Төсөл хэрэгжих явцад явцын тайлан гаргах нь үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу, зөв чигт явагдаж байгаа болон төсөөлөөгүй бэрхшээл, ололт зэргийг спонсорлогч талд мэдээлэх боломж ба цаашдын ажилд анхаарах зүйлүүдээ тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

Тайлангийн төгсгөлд тухайн хугацаанд хийсэн ажлуудад ерөнхий дүгнэлт өгнө. Тухайлбал: Төлөвлөгөөнд тусгагдсан ажил хэдэн хувьтай биелэгдсэн, явцын дунд тохиолдсон ололт амжилт, бэрхшээл, түүнийг хэрхэн даван туулсан тухай, үйл ажиллагаанд өгөх өөрийн үнэлгээ, цаашид анхаарах зүйл, талархал зэргийг бичнэ.

- *Хавсралт материал*

Төслийн баримт бичигт хавсралтаар илгээх материалыг тухайлан заасан байх тохиолдол байдаг. Ерөнхийдөө хавсралт материалд дараах зүйлүүдийг багтаах шаардлага байдаг. Үүнд: Байгууллагын танилцуулга, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, газрын гэрчилгээний хуулбар, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, зээл эргэн төлөх төлөвлөгөөний хүснэгт, одоогийн нөхцөл байдлыг харуулсан фото зураг зэрэг багтана.

